

БАТЛАВ,  
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН  
ДАРГА Р.ЭНХТАЙВАН



МОД ТАРЬСАН ГАЗРЫН УСАЛГААНЫ АСУУДЛЫГ  
ШИЙДВЭРЛЭХ УСАН САН /ХӨВ, ЦӨӨРӨМ/ БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ДААЛГАВАР

1	Үндэслэл:	<ul style="list-style-type: none"><li>- УИХ-ын 2010 оны 7-р сарын 15-ны өдрийн 48 тоот тогтоолоор баталсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.5.1.7 дахь заалт;</li><li>- УИХ-ын 2020 оны 5-р сарын 13-ны өдрийн 52 тоот тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 6.3.3 дахь заалт;</li><li>- Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.11 дахь заалт,</li><li>- Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.3.5.7 дахь заалт;</li><li>- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 6.3.2 дахь заалт;</li></ul>
2	Байршил:	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуу доорх байршилд: <ul style="list-style-type: none"><li>- 47°46'18.35"N, 106°42'56.65"E.</li><li>- 47°46'16.97"N, 106°43'3.36"E.</li><li>- 47°46'19.37"N, 106°43'4.72"E.</li><li>- 47°46'20.76"N, 106°42'58.41"E</li></ul>
3	Ажлын цар хүрээ:	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Түргэний гол дагуу хаврын шар ус болон зуны үерийн усыг хуримтлуулан экологид таатай нөлөө үзүүлэх, мод услах 7000 м <sup>3</sup> -ээс багагүй эзлэхүүнтэй усан сан /хөв, цөөрөм/ байгуулах.
4	Хугацаа:	<b>2024 онд:</b> <ul style="list-style-type: none"><li>- Зураг төслийг 100 хувь гүйцэтгэнэ.</li><li>- Барилга угсралтын ажлыг 100 хувь гүйцэтгэнэ.</li></ul>
5	Гүйцэтгэх ажлууд	<ul style="list-style-type: none"><li>- Байр зүйн зураглал, инженер-геологийн судалгаа, инженер геодези, топо зураглал боловсруулах ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэх;</li><li>- Хөв, цөөрөм (усан сан) байгуулах ажлын техникийн шийдэл, тоо хэмжээ, тогтворшилтын тооцоо, зураг төслийг боловсруулах, төсөв зохиох;</li><li>- Хөв, цөөрөм (усан сан)-гийн эзлэхүүнийг 7000 м<sup>3</sup>-аас багагүй байхаар тооцох.</li><li>- Далангийн найдвартай ажиллах хийц, хэлбэр хэмжээг тооцож тодорхойлох;</li><li>- Ус өнгөрүүлэх барилга байгууламжийн хийц, хэлбэр хэмжээг тодорхойлох;</li><li>- Болзошгүй үерийн аюулыг 1,5,10%-ийн хангамшилын зарцуулалтыг тодорхойлж, үерийн зардлыг 1%-ийн хангамшлаар тооцох;</li><li>- Төсвийг ESTIMATOR-PRO программаар тооцох ирүүлэх..</li></ul>

6	Баталгаажуулалт:	<ul style="list-style-type: none"> <li>- Захиалагчаас санал болгосон байршилд хөв цөөрмийн ажлын зураг төсвийг хийж Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэх;</li> <li>- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас зураг төсөлд санал авах;</li> <li>- Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийг газраас зураг төсөлд санал авч зөвшилцөх;</li> <li>- Шугам сүлжээний байгууллагуудтай зөвшилцөх;</li> <li>- Хөв цөөрөм (усан сан) байгуулах ажлын байгаль орчны үнэлгээ хийлгэх.</li> </ul>
7	Барилга угсралтын ажилд тавигдах шаардлагуу д:	<ul style="list-style-type: none"> <li>- Гүйцэтгэгч гэрээт ажлыг гүйцэтгэх ажлын график батлуулах;</li> <li>- Гүйцэтгэгч талбайн зохион байгуулалтын зураг хийж батлуулж мөрдөж ажиллах;</li> <li>- Гүйцэтгэгчийн барилга угсралтын ажилд хэрэглэх бүх материал нь шинэ, өмнө нь ашиглагдаагүй, аль болох үндэсний үйлдвэрийн материалыг ашигласан байх;</li> <li>- Гүйцэтгэгч байгууллага нь ажлын даалгаврын дагуу ажлыг чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.</li> <li>- Талбайд барилгын ажлын журналыг байнга хөтөлж, хяналтын инженерүүдийн өгсөн үүрэг даалгавар, шаардлага, дүгнэлтийн биелэлтийг гаргана.</li> <li>- Барилга угсралтын ажилд ашиглах материалыг урьдчилан захиалагч, ашиглагч байгууллагад танилцуулж зөвшилцөнө.</li> <li>- Улаан шугам тавьж ажлыг эхлэхээс өмнө мэргэжлийн байгууллагуудаас газар шорооны ажил эхлэх зөвшөөрлийг авсан байх.</li> <li>- Захиалагч, ашиглагч байгууллагын төлөөлөгчдийг байлцуулан үе шатны ажил тус бүрийг фото зургаар баталгаажуулан, акт үйлдэнэ.</li> <li>- Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгөх.</li> <li>- Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшгаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах ба хэрэв ямар нэг арга хэмжээ авалгүй гэнэтийн гамшигт өртвөл гүйцэтгэгч хариуцна.</li> <li>- Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна.</li> <li>- Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь импортын материал ашиглах нөхцөлд гарал үүсэл, тохирлын гэрчилгээ, сертификат, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргасан байх;</li> <li>- Аль болох үндэсний үйлдвэрийн материалыг ашиглах ба ингэхдээ “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ” лабораторийн шинжилгээний дүн хавсаргаж ирүүлнэ. Мөн орон нутгаас хэрэглэх элс, хайрганы шинжилгээний дүн, бетон зуурмагийн дээжээс сорилын шоо авч лабораторийн дүгнэлт гаргуулсан байна.</li> <li>- Чанаргүй хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.</li> <li>- Гэрээт ажлыг графикт хугацаанд бүрэн гүйцэтгэн Улсын</li> </ul>

		комиссоор байнгын ашиглалтад хүлээлгэн өгнө.
8	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага:	<ul style="list-style-type: none"> <li>- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Усны мэргэжлийн байгууллагын 1.1.2. “Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах” 1.1.4. Усны барилга байгууламж барих, сэргээн засварлах, шинэчлэх” үйл ажиллагааны чиглэлээр эрхтэй аж ахуйн нэгж, байгууллага;</li> <li>- Барилга, хот байгуулалтын яамны “Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын тусгай зөвшөөрөл”-ийн 1.3.5 “Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах” тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага</li> <li>- Барилга хот байгуулалтын яамны “Барилга угсралтын ажлын тусгай зөвшөөрөл”-ийн 2.3.1. Услалтын уст цэг, худаг, Услалтын системийн гидротехникийн барилга байгууламжийн ажил,</li> </ul>
9	Ажил гүйцэтгэхэд дагаж мөрдөх барилгын норм, дүрэм:	<p><b>Монгол Улсын хуулиуд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Үндсэн хууль</li> <li>- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;</li> <li>- Хот байгуулалтын тухай хууль;</li> <li>- Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль</li> <li>- Усны тухай хууль;</li> <li>- Хамгаалалтын бүс тогтоох тухай;</li> <li>- Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай;</li> <li>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;</li> <li>- Гамшгаас хамгаалах тухай хууль;</li> <li>- Галын аюулгүй байдлын тухай хууль;</li> <li>- Монгол Улсын Инновацын тухай хууль;</li> <li>- Газрын тухай хууль;</li> <li>- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;</li> <li>- Барилгын тухай хууль;</li> </ul> <p><b>Норм, нормативууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- БД 81-16-12 Зураг төслийн ажлын жишиг үнэ</li> <li>- БД 81-106-11 Усны барилга байгууламжийн зураг төслийн ажлын жишиг норм</li> <li>- ЗГ-ын 2009 оны 204 дүгээр тогтоол, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоол, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм</li> <li>- БНБД 33-01-03 Усны барилга, байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам</li> <li>- БНБД 81-33-10 Усны барилга байгууламжийн ажлын төсвийн суурь норм</li> <li>- БНБД 81-95-12 Барилгын төсөв зохиох дүрэм</li> <li>- БНБД 11-06-03 Зургийн ерөнхий инженер (ерөнхий архитектор) –ийн дүрэм</li> <li>- БНБД 11-07-04 Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл</li> <li>- БНБД 11-03-01 Барилгын инженер геологийн ажил</li> <li>- БД 81-105-11 Усны барилга байгууламжийн инженер, хайгуул судалгааны ажлын жишиг норм</li> <li>- БНБД 12-01-09 Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт</li> <li>- БД 12-101-05 Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- БНБД 11-08-06 Барилгын геодезийн ажил</li> <li>- БНБД 3.01.06-90 Барилгын орчны тохижилтын ажил</li> <li>- БНБД 3.02.01-90 Барилгын газар шороо ба буурь, суурийн ажил</li> <li>- БНБД 33-03-05 Голын гидротехникийн барилга байгууламж</li> <li>- БНБД 33-04-09 Усны барилга байгууламжийн буурь</li> <li>- БНБД 33-05-09 Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл</li> <li>- БНБД 33-06-09 Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц</li> <li>- БНБД 3.05.04-90 Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ, түүний барилга байгууламж</li> <li>- БНБД 40-102-06 Ус хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төсөллөх ба угсрах</li> <li>- БНБД 40-02-06 Усан хангамж, гадна сүлжээ ба байгууламж</li> <li>- БНБД 3.04.03-90 Байгууламж ба барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах</li> <li>- БНБД 33-07-09 Шороон боомт</li> <li>- БНБД 33-08-09 Бетон ба төмөр бетон боомт</li> <li>Бусад норм, норматив баримт бичиг, норм, дүрэм, заавар.</li> </ul>
10	Онцгой нөхцөл:	<ul style="list-style-type: none"> <li>- Хөрсний ус, цэвдгээс хамгаалах арга хэмжээ;</li> <li>- Үерийн уснаас хамгаалах арга хэмжээ;</li> <li>- Газар хөдлөлтөөс үзүүлэх ачаалал, эрсдэлийг тооцсон байх;</li> <li>- Үерийн ус, халиа тошин үүсэхээс хамгаалах арга хэмжээг тооцох;</li> <li>- Хүн, мал осолдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>- Орчны нөхөн сэргээлтийг хийх.</li> <li>- Усан сангийн орчимд гоц халдварт өвчинтэй сэг, зэм булшилсан эсэхийг сайтар нягтлах;</li> </ul>

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ГАЗРЫН ОЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.МӨНХБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН  
ОЙН ХЭЛТСИЙН УСНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ч.ДАМБАСҮРЭН